



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/01

Улаанбаатар
хот

**Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд
хийсэн дүгнэлтийг батлах**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн хийсэн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР

“Жуулчин Дютри Фрий” ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ХЭХ 03/01 тоот тогтоолын хавсралт

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ ” ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХИЙСЭН ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

“Жуулчин Дютри Фрий” Хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг дүгнэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн дараах дүгнэлтийг гаргалаа.

Таван Богд Групп нь 2016 оны 07 сард тус компанийн хяналтын багцын хувьцааг худалдан авсан бөгөөд үүнээс хойших хугацаанд тус компанийн үйл ажиллагааг амжилттай хариуцан явуулсаар байна.

Улаанбаатар төмөр замын вокзал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Хилийн шалган нэвтрүүлэх цогцолборт салбар дэлгүүрүүдээр татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Ковид-19 цар тахлын үр нөлөөнөөс шалтгаалан манай үндсэн үйл ажиллагаа урт хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй, үүнээс үүдэн салбар дэлгүүрүүдээс Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг салбар 2022 оны 08 дугаар сараас, Төмөр зам салбар 2023 оны 06 дугаар сараас тус тус үйл ажиллагааг богиносгосон цагаар ажиллаж байгаа нь компани цаашид алдагдлаа нөхөж ажиллахад нөлөөлөл үзүүлэхээр байна.

2025 онд компанийн 2 /Алтанбулаг, Төмөр зам/ салбар үйл ажиллагаа гаалийн баталсан хуваарийн дагуу эрхэлсэн бөгөөд санхүүгийн жилийн эцсийн тайлан бидний зорилтод түвшинд хүрээгүй байна. Өөрөөр хэлбэл борлуулалтын гүйцэтгэл 2025 онд 79.8%, ашгийн биелэлт 77.8 %-тай байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны цэвэр ашгийн гүйцэтгэл 61%-тай байна.

Тус компани 2025 оны төлөвлөгөөгөөр 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байсан үүнээс 1.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь төлөвлөгөөгөө 79.8%-тай биелүүлсэн байна. Мөн хүүгийн орлогын зөрүүгээс 158.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Компанийн хэмжээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 2024 оны 05 сараас эхлэн чөлөөт бүс нээгдсэнтэй холбоотой борлуулалтын орлого буурсан боловч компани нөөц бололцоогоо дайчлан ажилласан гэж дүгнэж байна.

Цаашид татваргүй барааны дэлхийн стандарт жишигт нийцсэн дэлгүүрийн үйлчилгээг нэвтрүүлэн олон улсын болон дотоодын зорчигчид, жуулчид болон татваргүй барааны дэлгүүрээр үйлчлүүлэх эрх бүхий этгээдэд үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөсөн байгааг тэмдэглэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/02

Улаанбаатар
хот

Компанийн 2026 оны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.16 дах хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн 2026 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлснийг хавсралтаар баталсугай.
2. 2026 оны санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/, Ерөнхий нягтлан бодогч В.Алтантулга нарт тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР

“Жуулчин Дютри Фрий” ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ХЭХ03/02 тоот тогтоолын хавсралт 1

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН 2026 ОНЫ
САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Санхүүгийн үзүүлэлт	2026
	Төлөвлөгөө
Цэвэр борлуулалтын орлого	1,600,890,635.91
Нийт борлуулалт	1,600,890,635.91
Борлуулалтын буцаалт	-
Борлуулалтын хөнгөлөлт	-
Борлуулалтын үнийн бууралт	-
Өртөг	914,368,944.74
Нийт Ашиг	686,521,691.17
Борлуулалт, маркетингийн зардал	335,308,701.82
Ажилчдын цалин хөлс, хоол унаа хөнгөлөлт, купон	116,393,138.51
Ажилчдын шагнал, урамшуулалын зардал	39,800,000.00
Байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал	19,524,148.00
Хуулийн дагуу аж ахуй нэгжээс төлсөн тэтгэмж	-
Албан татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн зардал	19,649,315.48
Томилолтын зардал	-
Бичиг хэргийн зардал	1,017,549.00
Шуудан холбооны зардал	7,010,709.79
Мэргэжлийн үйлчилгээ	6,060,340.00
Ажилчдын сургалт, заавар, чиглүүлэг, хурал, уулзалт	-
Даатгалын зардал	270,835.50
Ашиглалтын зардал	9,931,431.50
Засварын зардал	5,453,066.71
Элэгдэл, хорогдлын зардал	10,056,729.84
Түрээсийн зардал	87,707,412.00
Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын зардал, дотоод хэрэгцээ	3,148,268.50
Тээврийн зардал	-
Шатахууны зардал	-
Харилцагчийн урамшуулал, идэвхижүүлэлт	3,600,000.00
Маркетинг, идэвхижүүлэлт	-
Маркетинг судалгаа, бусад	-
Хөдөлмөр хамгаалал	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	2,907,675.00
Менежмент, франчайзын төлбөр	-
Бизнес уулзалт	-
Ажилчдыг идэвхижүүлэх болон баяр ёслол, уралдаан тэмцээний зардал	3,100,000.00
Бэлэг дурсгал	-
Баталгаат засварын нөөц	-
Зуучлалын төлбөр	-
Тендерийн зардал	-
Дээж шинжилгээтэй холбоотой зардал	-
Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдалаас хамгаалах сан	-
Бусад	-
Ахиуц ашиг	351,212,989.35

Ерөнхий ба удирдлагын зардал	442,729,835.89
Ажилчдын цалин хөлс, хоол унаа хөнгөлөлт, купон	250,589,313.50
Ажилчдын шагнал, урамшуулалын зардал	-
Байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал	31,133,585.50
Хуулийн дагуу аж ахуй нэгжээс төлсөн тэтгэмж	-
Албан татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн зардал	4,086,740.41
Томилолтын зардал	6,598,637.30
Бичиг хэргийн зардал	578,461.00
Шуудан холбооны зардал	1,414,548.84
Мэргэжлийн үйлчилгээ	13,726,019.94
Ажилчдын сургалт, заавар, чиглүүлэг, хурал, уулзалт	-
Даатгалын зардал	1,722,366.85
Ашиглалтын зардал	-
Засварын зардал	15,659,266.67
Элэгдэл, хорогдлын зардал	33,205,503.61
Түрээсийн зардал	51,045,308.75
Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын зардал, дотоод хэрэгцээ	3,156,586.00
Тээврийн зардал	-
Шатахууны зардал	16,225,039.53
Зар сурталчилгааны зардал	1,025,310.36
Хөдөлмөр хамгаалал	1,750,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	-
Менежмент, франчайзын төлбөр	-
Бизнес уулзалт	-
Ажилчдыг идэвхижүүлэх болон баяр ёслол, уралдаан тэмцээний зардал	5,450,000.00
Бэлэг дурсгал	5,500,000.00
Бусад	-
Үйл ажиллагааны ашиг	(91,516,846.54)
Бусад орлого	281,985,563.49
Бусад зарлага	4,084,151.36
Бусад ашиг (алдагдал)	992,205.67
EBIT	187,376,771.26
Санхүүжилтийн зардал	-
EBT	187,376,771.26
Татварын зардал	19,260,749.87
Тайлант хугацааны цэвэр ашиг/ (алдагдал)	168,116,021.40



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/03

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.15, 77 дугаар зүйлийн 77.3, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр хугацаанаас нь өмнө дуусгавар болохыг баталсугай.
2. Энэхүү тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болж буй талаар гишүүдэд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Бат-Эрдэнэ/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт тус тус холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/04

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.15, 77 дугаар зүйлийн 77.1, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүдээр

- 1) Ц.Баатарсайхан
- 2) Д.Хулан
- 3) Ц.Оюунцэцэг
- 4) Ц.Отгонсүрэн
- 5) Ц.Отгонбаяр
- 6) Ч.Мөнхтуяа

Хараат бус гишүүдээр

- 1) Д.Байгальмаа
- 2) Д.Болормаа
- 3) Д.Уянга

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд нь гишүүний үүргээ хууль болон компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх, компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж, шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт тус тус холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР